

11

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОЛОН УЛСЫН ШИЛЖИЛТИЙН
МЕХАНИЗМ, ТҮҮНИЙ МОНГОЛД ҮЗҮҮЛЖ
БАЙГАА НӨЛӨӨ**

Д.Туяа

Оршил

Эрдэм шинжилгээний өгүүлэлдээ ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын бүтэц, мөн чанарыг улс хоорондын эдийн засгийн идэвхтэй хүн амын шилжилт, солилцоог зохион байгуулах, үйл ажиллагааг хангах арга болохын хувьд судалж илрүүлсэн. Механизмын үйлдлийн объектив хүчин зүйлсүүд болон субъектив шалтгаануудыг, нөлөөллийн объект, субъектийг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл ажиллах хүчийг эзэмшигч байдаг иргэн, Засгийн газар, төр, үндэсний болон үндэсний гадуурхи нийгмийн байгууллагуудыг үйлдлийн объект, субъектэд тооцсон. Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмыг хэрэгжүүлэх зорилго, дэд зорилгыг томъёолсон. Тавьсан зорилгодоо хүрэх арга хэрэгсэлийг гаргаж ирсэн. Үр дүнгийн үнэлгээний шинжүүрийг санал болгосон. Шилжилтийн бодлого болон нийгмийн орчны үүргийг, түүнчлэн ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын үйл ажиллагааг илрүүлсэн.

Түлхүүр үг: ажиллах хүч, олон улсын шилжих хөдөлгөөн, олон улсын шилжих хөдөлгөөний механизм, эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөрийн нөөц, олон улсын шилжих хөдөлгөөний хүчин зүйлс, олон улсын шилжих хөдөлгөөний субъектүүд.

Key words: labour force, international migration, mechanism of international migration, economically active population, manpower, factors of international migration, subjects of international migration.

Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн мөчлөг нь хүмүүсийн амьдралын үйл ажиллагааны бүх салбарт ул мөр үлдээж байдаг. Дэлхийн эдийн засгийн хямралын нөхцөлд ажил эрхлэлт, ялангуяа гадаадын ажилчдын ажил эрхлэлтийн асуудал хурцаар гарч ирсэн. Бүх үйлдвэр аж ахуйн үйлдвэрлэлийн

уналт нь хөдөлмөрийн зах зээл дээрх ажилгүйчүүдийн тооны өсөлт, хүн амын идэвхжилийг бий болгодог. Хүндэрч байгаа байдалд шилжих хөдөлгөөн нь нэг талаас тухайн улсын хөдөлмөрийг зохион байгуулах боломжийг харуулж байна. Нөгөө талаас хямралын даяаршлын шинж байдал нь улсаас шилжих хөдөлгөөнийг хянах, шилжигсэдтэй холбоотой явуулж байгаа бодлогоо чангатгахыг шаарддаг. Энэ нь ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөний механизмын мөн чанар, бүтцийг судлах зайлшгүй байдалд хүргэдэг.

Хэрвээ ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөнийг макро эдийн засгийн үйл явц гэж үзвэл, түүний механизм нь аж ахуйн механизмын хэсгийг өөртөө агуулдаг. Тэр нь аж ахуйн механизмын хэсэг болохын хувьд өөрийн бүтэц, анхны байдал болон эцсийн үр дүнтэй байдаг. Ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөний механизм нь үндэсний эдийн засгийн хоёр систем болох улс хооронд ажиллах хүчнийг шилжүүлэх солилцооны үйл ажиллагааг хангах, зохион байгуулах арга гэж тодорхойлж болно.

Иймээс ажиллах хүчний «хөдөлмөрийн чадвартай байдал», онцгой төрлийн бүтээгдэхүүн гэсэн ойлголтод үндэслэн ажиллах хүчний шилжих хөдөлгөөнийг янз бүрийн онцлог шалтгаанаар бий болсон ажиллах болон/буюу амьдрах байрлалаа өөрчлөх зорилготой эдийн засгийн идэвхтэй хүн амын нутаг дэвсгэрийн шилжилтийн үйл явц гэж ойлгож болно. «Эдийн засгийн идэвхитэй хүн ам» гэсэн ойлголт нь 1996 оноос эхлэн олон улсын хөдөлмөрийн статистикийн нэр томъёонд орсон. Олон улсын аргачлалын дагуу эдийн засгийн идэвхитэй хүн ам гэдэг нь тухайн улсын нийт ажиллагсад болон ажилгүйчүүдийн нийлбэрээр тодорхойлогдоно. Эдийн засгийн идэвхитэй хүн амыг нөгөө талаар тус улсын ажиллах хүч гэдэг¹¹. Хэрвээ ажиллах хүчний тухай ярихдаа түүнийг бүтээгдэхүүн гэж авч үзвэл, ийм бүтээгдэхүүний хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт нь эдийн засгийн идэвхитэй хүн амаар, өөрөөр хэлбэл, өөрийн бүтээгдэхүүн болох ажиллах хүчийг идэвхтэй санал болгодог хүн амаар бүрэлдэн тогтдог. Ажиллах хүчийг эзэмшигч иргэн нь янз бүрийн сайн дурын болон аргагүй шалтгаанаар улс хооронд шилжиж болдог. Хэрвээ иргэн оршин суух улсаа өөрчилсөн бол шилжин очсон улсаа өөрийнхөө ажиллах хүчийг санал болгодог. Энэ нь хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлтийг нэмэгдүүлж, цалин хөлсний хэмжээнд нөлөөлдөг. Иймд бид ажиллах хүчний орох урсгалын тухай, түүнийг бий болгосон шалтгаанаас хамааралгүй ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай ярих болно.

Ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөний механизм нь тодорхой нөхцөлд, тодорхой хүчин зүйлсүүдийн нөлөөн дор биелэгддэг.

¹¹ Б.Баярдаваа, Д.Гансүлд. *Макро экономикс. Улаанбаатар. 2006.*

Хүндэрч байгаа нөхцөл болон хүчин зүйлүүд нь бидний үзэж байгаа механизмын эхлэлийн байдлын мөн чанарыг бүрдүүлдэг.

Нөхцөл - нь шилжих хөдөлгөөний үйлдэл байнга явагддаг байдал юм¹². Нөхцөл гэдэгт ямар нэг нутаг дэвсгэрийн объектив шинж чанар, хүрээлэн байгаа орчны бүх бүрэлдэхүүнийг ойлгож болно. Ямар нэгэн үйл явцад нөлөөлдөг тодорхой нөхцөлийн тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд нь энэ үйл явцын хүчин зүйлсүүд байдаг¹³.

Шилжих хөдөлгөөний хүчин зүйлсүүд нь шилжих хөдөлгөөний үйл явцад нөлөөлдөг бөгөөд тэдгээрийн нөлөөллийг зохицуулах хэлбэрээс нь хамаарч дараах байдлаар ангилдаг:

- **удирдагддаггүй** энэ нь байнга нөлөөлдөг хүчин зүйлсүүд,
- **«түр зуурын»** гэж нэрлэгддэг хүчин зүйлсүүд нь шууд бус байдлаар нөлөөлдөг.
- **хувьсах** гэдэг нь зохицуулагддаг хүчин зүйлсүүд юм.¹⁴


Удирдагддаггүй хүчин зүйлсүүдэд газар зүйн байрлал, байгаль цаг уурын нөхцөл болон бусад байгалийн бүрэлдэхүүн хэсгүүд, «түр зуурын» хүчин зүйлсэд - хүн ам зүйн, үйлдвэрлэлийн, нийгмийн бүтэц гэх мэт, зохицуулагддаг хувьсах хүчин зүйлсэд - цалин хөлсний салбар дахь үндэсний бодлогын бүрэлдэхүүн хэсгүүд, боловсон хүчин, татвар, шилжих хөдөлгөөний бодлого болон бусад орно. Дээр дурьдсан хүчин зүйлсүүдийг нутаг дэвсгэрийн объектив шинж чанар гэж нэрлэж болно.

Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний механизмын субъектив тал нь шилжих хөдөлгөөний зорилгод нийцсэн хувь хүний янз бүрийн үнэлгээнд илэрдэг. Мэдлэг чадвартай шилжигч хүн нь бүс нутгийн эдийн засаг, нийгмийн объектив нөхцөлүүд, амьдарч байгаа улс орныхоо үндэсний бодлогыг шилжихээр төлөвлөж байгаа улсынхаа тухайн үзүүлэлтүүдтэй харьцуулж шилжих тухай шийдвэрээ гаргадаг. Зорилгод нийцсэн үнэлгээ нь шилжигчийн хувийн шинж чанараас, түүний хэрэгцээнээс, хувийн эрхэмлэн дээдлэх үзэл баримтлалаас хамаарах болно (зураг.1).

¹² Одегов Ю.Г., Руденко Г.Г., Экономика труда. М., 2007

¹³ Рыбаковский Л.Л., Механизмы формирования миграционных потоков // Миграция и развитие. М., 2007

Зураг.1. Шилжих тухай шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлсүүд



Хүндэрч байгаа объектив нөхцөл дэх шилжигчийн субъектив үнэлгээ нь шилжих хөдөлгөөний шалтгааныг ойлгох ойлголттой холбоотой. Хэрвээ шилжих хөдөлгөөний хүчин зүйлсүүдийг нутаг дэвсгэрийн объектив шинж чанар гэж нэрлэж болох бол шилжих шалтгаанууд нь тухайн нутаг дэвсгэрт амьдрах нөхцөл ялгаатай байхыг харуулсан субъектив ойлголт юм.

Олон улсын шилжих хөдөлгөөний шалтгааныг эдийн засгийн болон эдийн засгийн бус шалтгаан гэж ангилдаг. Эдийн засгийн шалтгаан нь эдийн засгийн хөгжил, цалин хөлс, ажилгүйдлийн түвшний ялгаа, тодорхой нутаг дэвсгэрийн хүн амын нягтралын үнэлгээгээр хязгаарлагддаг. Эдийн засгийн бус шалтгаанууд нь сайн дурын болон аргагүй шалтгаан гэж байдаг. Сайн дурын шалтгаан нь гэр бүлийн, илүү өндөр нийгмийн статусыг хайх гэх мэт байдаг. Аргагүй гэдэг нь улс төрийн, үндэсний, шашны, экологийн, арьс өнгөний гэх мэт шалтгаанууд байдаг.


Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмыг үнэлэхийн тулд шилжих хөдөлгөөний объектив хүчин зүйлсүүд, тодорхой хувь хүний субъектив үнэлгээг тооцох нь зүйд нийцнэ.

Ямар ч механизм нь хувьсан өөрчлөгдөх үйл явц, эрс өөрчлөлтийн үүрэг, зорилго, объект, субъектүүд, зорилгод хүрэх арга, түүнд хүрэх хэрэгсэл, мөн эрс өөрчлөлтийн үр дүн, үр дүнгийн үнэлгээний шинжүүрийг санал болгодог¹⁵. Санал болгож байгаа бүтэцтэй холбоотойгоор ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөний механизмыг авч үзье. (зураг.2.)

Олон улсын шилжих хөдөлгөөний механизмын субъектүүд

1. Засгийн газар: шилжих хөдөлгөөний үзэл санаа, улс орны шилжих хөдөлгөөний бодлогыг тодорхойлогч, шилжих хөдөлгөөний асуудлаар хууль болон хууль зүйн баримт бичгийг боловсруулж томъёолдог.

¹⁵ Народонаселение: Энциклопедический словарь.М.,1994



Зураг.2. Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын бүтэц

Хөдөлмөрийг хүн гэдэг утгаар халамжлах асуудал нь ажил олгогч төдийгүй улс орны бодлогын хэмжээнд авч үзэх хурц асуудал юм.

Улс орны засгийн газар нь тухайн орны эдийн засгийн болон геополитикийн сонирхолыг ёсчлон дагаж шилжих хөдөлгөөний бодлогыг боловсруулдаг. Шилжих хөдөлгөөний бодлого гэдэгт эдийн засаг, хүн ам зүйн, геополитикийн болон бусад зорилгыг мөрдөж шилжих хөдөлгөөний үйл явцыг

зохицуулах (хоёр талт болон олон талт) олон улсын зөвшилцөл, хэлэлцээр болон хууль эрх зүйн баримт бичиг, тусгай арга хэмжээний системийг ойлгодог. Олон улсын шилжих хөдөлгөөний салбарт энэ бодлого нь улс оронд орох болон иргэншлээс хасах, улс оронд гадаадын ажиллах хүчийг ашиглах, гадаадад ажиллаж байх хугацаанд шилжин ирсэн ажилчны нийгмийн хамгааллын системийг бүрдүүлэх, дүрвэгсдийн урсгал болон тэдгээрийн нийгмийн хамгааллын дүрэм тогтоох зэргийг ойлгодог. Шилжих хөдөлгөөний бодлого нь цагаачлан ирэгсдийн урсгалд гол анхаарлаа хандуулдаг.

Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр

эрхлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барихаар тогтов. ОУХБ-аас Монгол Улстай хамтран ажиллах 2010-2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналаа боловсруулан хүргүүллээ¹⁶.

Дэлхийн туршлагаас харахад ажиллах хүчний олон улсын шилжих хөдөлгөөний үйл явц нь улс орны үндэсний хууль дүрмээр болон олон улсын эрх зүйн баримт бичгээр зохицуулагддаг байна. Иймд хууль дүрэмд 2 чиглэлийг тусгадаг: нэг нь нээлттэй эдийн засаг буюу түүнтэй холбоотойгоор хүн амын болон хөдөлмөрийн нөөцийн чөлөөт шилжилт, нөгөө нь протекционизм буюу олон улсын шилжих хөдөлгөөний салбар дахь хязгаарлалт байдаг. Үндэсний сонирхол нь олон улсын байгууллага, нийгэмлэгүүдийн сонирхолтой зөрчилдөж болно. Энэ нь ихэнхдээ олон улсын шилжих хөдөлгөөний салбар дахь олон улсын гол үндсэн баримт бичгийн улс орны баталгааг хориглодог.

2. Шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулдаг улсын бүтэц.

Энэ нь Хөдөлмөрийн Яам буюу Гадаад хэргийн яаманд байгуулагдсан цагаачлалын үндэсний алба юм. Тухайн улс орны мэргэшсэн ажилтантай, зохих төсөвтэй шилжих хөдөлгөөний төв байгууллага нь ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын үр ашигтай ажиллагааны заавал болон зайлшгүй нөхцөл байдаг.

НХХ-ийн сайдын 2006 оны 52 дугаар тушаалаар батлагдсан “Ажилд зуучлах

үйлчилгээг бүртгэх журам”-ыг шинэчлэн “Хөдөлмөр зуучлалын албыг бүртгэх журам” гэж нэрлэсэн. Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хүрээнд байгуулах хэлэлцээрт ажиллах хүчний шилжих хөдөлгөөний асуудлыг тусгах, Монгол Улсад шаардлагатай байгаа ажил, мэргэжил, мэргэшлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзах, мөн мэдээлэл технологи, гадаад хэл, зөвлөх үйлчилгээний чиглэлээр аутсорсингийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход анхаарал хандуулах талаар санал боловсруулан Гадаад хэргийн яаманд хүргүүлэв¹⁷.

¹⁶ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2010 оны 2 дугаар сард хийсэн ажлын тайлан

¹⁷ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2010 оны 2 дугаар сард хийсэн ажлын тайлан

Шилжилтийн журмыг үр ашигтай байлгахын тулд дараах зүйлсийг хийх хэрэгтэй¹⁸:

- ✓ Мэргэшсэн боловсон хүчинтэй, зохих төсөвтэй шилжилтийн хөдөлгөөний асуудлыг эрхэлсэн төв байгууллагатай байх,
- ✓ Төв, бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргааны хоорондох албан үүргийг нарийн тодорхой хуваарилах,
- ✓ Найдвартай мэдээллийн системтэй байх,
- ✓ Хүн амын шилжин суурьших, шилжин явах, шилжин ирэх, иргэн болох асуудлаарх эрх зүйн үндсийг бүрдүүлэх,
- ✓ Хууль болон бодит байдлын хоорондын зөрчлийг тодорхойлох хяналтын механизм болон эдгээр зөрчсөн байдлыг засварлах мэргэжлийн онцлог хэрэгсэлтэй байх,
- ✓ Хилийн хяналтыг үр ашигтай гүйцэтгэх техникийн боломжтой байх,
- ✓ Удирдлага болон боловсон хүчнийг бэлтгэх системтэй байх.

3. Үндэсний болон үндэстэн дамнасан нийгмийн байгууллагууд.

Өнөө үед улс орны шилжилтийн бодлого, хүлээн авч байгаа орны шилжин ирэгсдийн түргэн хугацаанд орчиндоо тохирох байдал, иргэний шилжилтийг цэгцтэй, журамтай болгоход Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ) болон дүрвэгсэд, аргагүй шилжин суурьшигчдын хэрэг эрхлэх НҮБ-ийн Дээд Комиссарын Удирдлага гэх мэт үндэсний гадуурх байгууллагууд илүү чухал нөлөөг үзүүлдэг. Эдгээр байгууллагуудаас явуулдаг хурал, зөвлөгөөн нь олон улсын шилжилтийн болон хөгжлийн асуудлаар олон улсын хэм хэмжээний үндсийг боловсруулж гаргадаг.

ПЕКК-ийн олон улсын “Ази-Номхон Далайн орнуудын Хүн ам зүйн өөрчлөлт ба Олон улсын ажиллах хүчний шилжилт: Бизнес ба Хамтын ажиллагаа” хурал 2008 оны 3 сарын 25-26 өдрүүдэд Сеул хотноо зохион байгуулагдлаа.

Гадаад шилжих хөдөлгөөн, ялангуяа ажиллах хүчний шилжилт бол дан ганц нэг улс орны асуудал бус, улс үндэстэн дамнасан, бүс хоорондын хамтын үйл ажиллагаатай холбоотой, тэрхүү хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлэхийг шаардсан асуудал юм. Ажиллах хүчний шилжилтийн эдийн засаг, бизнес дэх үр дагаврыг зохицуулах талаарх эхлэлийг энэхүү хурлаар тавьсан. Ажиллах хүчний шилжилт гэсэн асуудлын дор мэргэжлийн ур чадвар бага ажилчдыг өндөр ур чадвартай болгох, хууль бус шилжигчид, баримт бичгийн зөрчилтэй иргэдийн асуудлыг зохицуулах, эдгээр бүх шилжигчдийн эрхийг хамгаалах, тэдэнд туслах зэрэг олон асуудлыг авч үзэж байгаа юм. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Хүн амын сургалт судалгааны төвийн тэргүүн, тэнхмийн

¹⁸ Ионцев.В., Международная миграция, глобализация и развитие//Миграция и развитие . М.,2007

эрхлэгч Доктор Цогтсайханы Болормаа оролцож Монгол улсын илтгэлийг тавьсан. Илтгэл нь сүүлийн 15 жилийн хүн ам зүйн өөрчлөлт, шилжилт, ялангуяа, хүн амын насны бүтцийн томоохон өөрчлөлт (хүн ам зүйн цонх нээгдэж буй үеийн боломж, хэрэгцээ шаардлага), хүн амын төрөлт, нас баралтын эрчимтэй бууралт, гадаад шилжих хөдөлгөөний эрчимжилт, тэдгээрийн үр дагаврын талаар танилцуулсан. Илтгэлдээ 2005 онд хийгдсэн “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлт, үр дагавар” сэдэвт гурван улсыг (БНСУ-д ажиллаж буй 393, БНЧУ-д ажиллаж буй 200, АНУ-д ажиллаж буй 102 хүнийг хамруулсан судалгааны ажил) хамарсан түүвэр судалгаанаас гарсан гол үр дүнгийн талаар болон Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдлын талаар нэлээд дэлгэрэнгүй танилцуулсан

Олон улсын байгууллагаас гадна үндэсний Засгийн газрын бус байгууллагууд байдаг. Тэдгээр нь шилжилт, шилжин суурьшигчдын асуудлыг эрхэлдэг. Олон оронд энэ байгууллага нь тухайн байдалд нөлөөлөх чадвартай, бодит хүчин байдаг.

2001 оноос хэрэгжиж эхэлсэн “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулиар Монгол улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол улсад хөдөлмөр эрхлүүлэх, тэдний эрх, ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд манай улсын олон мянган иргэн гадаадад ажиллахаар хилийн чанадыг зорих болсон. Түүнчлэн Монгол улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар ажиллах хүч гаргах асуудлыг зохицуулж байна.

4. Иргэн нь ажиллах хүчийг эзэмшигч юм.

XX зууны сүүлчээр ажиллах хүчийг дайчлан ашиглах явдал өсөх болсон гэдгийг онцлон тэмдэглэе. Нилээд олон эдийн засагчдын ажлуудад «үндэстэн дамнасан ажиллах хүч» гэсэн ойлголт бий болсон. Эдгээр ажилчид нь өөрийнхөө мэдлэг, туршлага, чадварыг санал болгож нэг орноос нөгөө орон руу байнга шилжин явж байдаг.

Хүн амын шилжилтийн хөдлөл нь амьдран суурьшиж байгаа нийгмийн орчноос хамаардаг. Тухайн оронд амьдарч байгаа иргэд нийгмийн орчинг бий болгодог. Нийгэмд бүрэлдэн тогтдог аж ахуйн механизм нь нийгмийн ухамсарын тусгал бөгөөд нийгмийн орчныг бүрдүүлэхэд нөлөө үзүүлдэг. Нийгмийн орчин нь мөн чанартаа иргэдийн хувийн сэтгэл санааны болон зан байдлын шинж чанарыг бүрдүүлэхэд нөлөөлнө. Тэдгээрийн хүрээлэн байгаа орчин, хэрэгцээ, хүлээлт таамаглалын ойлголт нь шилжилтийн зорилгоо үнэлэх, оршин суух ба/эсвэл ажлын байраа өөрчлөх тухай шийдвэр гаргахад нөлөөлөх болно.

Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын зорилго. Нутаг дэвсгэрийн хил дамжиж, улс орон дамжиж эдийн засгийн идэвхтэй хүн ам

шилждэг боловч үзэж байгаа хувиран өөрчлөгдөх үйл явцын зорилго нь оршин суух ба /эсвэл ажлын байрны өөрчлөлт гэж тооцогдож болно.

Зорилго нь дэд зорилгоор сарнигдаж болно. А.Маслоугийн хэрэгцээгээ захирах онол ёсоор иргэний хувийн зорилго нь дараах байдлаар дүрслэгдэнэ. (хүснэгт)

Шилжигсдийн тавьсан зорилтын хэд хэдэн хэрэгцээ нь хувь хүний онцлогоос хамаарч нэг хугацаанд хангагдахаар төлөвлөгдөж болно. Тодорхой зорилго бүрийн хүрээнд тэдэнд зорилгодоо хүрэх нөхцөлийг хангах бодлогууд бий болдог.

Тавьсан зорилгодоо хүрэх аргуудыг хуулиар зөвшөөрөгдсөн болон хуулиар зөвшөөрөгдөөгүй гэж ангилдаг. Хуулиар зөвшөөрөгдсөн гэдэг нь хууль журмын үндсэн дээр хил давж цаашдын хөдөлмөрөө зохион байгуулах, эсвэл «хавсарсан» шилжилтийн хүрээнд хөдөлмөрийн зохион байгуулалт хийх явдал юм. Хуулиар зөвшөөрөгдөөгүй аргууд нь хууль бусаар, эсвэл албан ёсоор хил давж дараа нь хуулиар зөвшөөрөгдөөгүй хөдөлмөр эрхлэх явдал байдаг.

Шилжигсдийн тавьсан зорилтын хэд хэдэн хэрэгцээ нь хувь хүний онцлогоос хамаарч нэг хугацаанд хангагдахаар төлөвлөгдөж болно. Тодорхой зорилго бүрийн хүрээнд тэдэнд зорилгодоо хүрэх нөхцөлийг хангах бодлогууд бий болдог.

Хүснэгт 1

Иргэдийн хэрэгцээнээс хамаарсан хувийн зорилго

Иргэдийн хувийн зорилго	Хэрэгцээ
<ul style="list-style-type: none"> ➤ Өөрийгөө боловсруулах, өөрийнхөө бүтээх боломж, мэргэжлийн дадал чадвараа илрүүлэх ➤ Бизнесийн байгууллагын гадаад орны туршлагатай танилцах, мэргэжлээ дээшлүүлэх, ➤ Гадаадын эдийн зсагт хөрөнгө оруулалт хийх 	Өөрийгөө боловсруулах
<ul style="list-style-type: none"> ➤ Тушаал түргэн дэвших, ➤ Боловсрол эзэмших, ➤ Гадаад хэл сурах 	хүндлэгдэх
<ul style="list-style-type: none"> ➤ Гэр бүлээ байгуулах, ➤ Эх орондоо буцаж ирэх, ➤ Амьдрах нийгмийн нөхцөлөө сайжруулах 	нийгмийн
<ul style="list-style-type: none"> ➤ Тогтвортой ажлын байрны батлагааг олж авна ➤ Амьдрах экологийн болон байгал-цаг уурын нөхцөлөө сайжруулна ➤ Ямар нэг хүчирхийлэл, мөрдлөгт өртөх аюулыг таслан зогсооно 	Аюулгүй байдлын
<ul style="list-style-type: none"> ➤ Илүү өндөр хөдөлмөрийн хөлстэй ажлын байранд хөдөлмөрлөх, ➤ (багцаалбал ажилгүй юм шиг) тийм хөдөлмөр эрхлэх 	физиологийн

Тавьсан зорилгодоо хүрэх *аргуудыг* хуулиар зөвшөөрөгдсөн болон хуулиар зөвшөөрөгдөөгүй гэж ангилдаг. Хуулиар зөвшөөрөгдсөн гэдэг нь хууль журмын үндсэн дээр хил давж цаашдын хөдөлмөрөө зохион байгуулах, эсвэл «дүүжмэг» шилжилтийн хүрээнд хөдөлмөрийн зохион байгуулалт хийх явдал юм. Хуулиар зөвшөөрөгдөөгүй аргууд нь хууль бусаар, эсвэл албан ёсоор хил давж дараа нь хуулиар зөвшөөрөгдөөгүй хөдөлмөр эрхлэх явдал байдаг.

Шилжилтийн зорилгод хүрэх *хэрэгсэлийг* хувь хүн өөрөө бие дааж тодорхойлдог. Энэ нь эсвэл гадаад улсад явах зохион байгуулалттай явалт, эсвэл зохион байгуулалтгүй олон улсын шилжилт байж болно.Хэрвээ шилжилтийн санааны биелэлт нь гадаадад хөдөлмөр эрхлэх улсын болон хувийн байгууллагын тусламжтайгаар хийгдсэн бол энэ нь зохион байгуулалттай шилжилт болно. Дээрх байгууллагууд нь хөдөлмөрийн улсын төв байгууллагын хяналтан дор ажилладаг бөгөөд хилийн чанадад ажиллаж байгаа иргэдийнхээ тэдэнд олгосон баталгааг хангах ёстой. Гадаадад ажиллах хүч илгээх байгууллага нь эсвэл гадаадын ажил олгогчийн итгэлтэй төлөөлөгч байна, эсвэл зуучлагчийн шинжтэй байна. Гадаадад хөдөлмөр эрхлэх хүрээний ихэнх хэсэгт арилжааны салбар үйлчилдэг. Зохион байгуулалтгүй шилжилт гэдэг нь гадаадад бие дааж хөдөлмөр эрхлэх явдал юм. Энэ тохиолдолд шилжилтийн зорилгыг биелүүлэхэд хэрэглэх хэрэгсэл нь нилээд өргөн байдаг. *Объект* нь өөрчлөлт хийх харилцаа, өөрөөр хэлбэл, үйлдэл нь юунд чиглэгдэж байгааг харуулна. Иймээс объект нь амьдран байгаа болон зорьж байгаа улсын хөдөлмөрийн нөөц юм.

Үр дүн нь тухайн орны хөдөлмөрийн нөөцийн тоон болон чанарын шинж чанар байна.

Ажиллах хүчний олон улсын механизмын нөлөөний үр дүнг үнэлэхдээ үр дүнгийн үнэлгээний шинжүүрүүдийг тодорхойлох хэрэгтэй. Түүнд дараах зүйлсийг дурдаж болно:

- Улс орон болон бүс нутгийн хөдөлмөрийн нөөцийн тоон болон чанарын бүтцийн харьцаа нь улсын сонирхолд бүрэн зохицож байх,
- Ажил эрхлэлтийн байдлыг сайжруулах,
- Хөдөлмөрийн хөлс (ажиллах хүчний үнэ)-ийн түвшний өөрчлөлт,
- Хүн ам зүйн байдлыг сайжруулах, хүн ам зүйн тэнцвэрийг хадгалах,
- Улс орон дахь нийгмийн байдлыг өөрчлөх,
- Шилжигсдийн хувийн зорилго биелэх,
- Эдийн засгийн өсөлт гэх мэт байна.

Хувьсан өөрчлөгдөх үйл явц болох ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын үр дүн нь амьдарч байгаа оронд болон зорьж байгаа оронд, мөн түүнчлэн даяаршлын дэлхийн эдийн засгийн интегралчлалын үйл явц явагдаж байгаа үед бүхэлдээ заавал үнэлэгдэх ёстой.

Олон улсын шилжилт нь хүлээн авч байгаа оронд дараах эерэг нөлөөг үзүүлж болно:

- ✓ Биеийн хүчний хүнд хөдөлмөртэй, доогуур хөдөлмөрийн хөлстэй салбарт хямд ажиллах хүчийг оруулах,
- ✓ Ажил эрхлэлтийг илүү уян хатан зохицуулах боломжтой болох (хямрал болон ажилгүйдэл бий болох тохиолдолд гадаадын ажилчдыг эхний ээлжинд халж болно),
- ✓ Томоохон дэд бүтцийн төслийг гүйцэтгэхэд гадаадын мэргэжилтнийг оролцуулах,
- ✓ Өндөр боловсролтой мэргэжилтнийг бэлтгэх мэргэжлийн сургалт, боловсролын салбарт хэмнэлттэй байх,
- ✓ Шинжлэх ухаан, техникийн хүчин чадлаа өсгөх,
- ✓ Гадаадаас шилжин ирэгсэд ирснээр бага хүн амтай оронд эдийн засаг хөгжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэмэлт эрэлт бий болсноос үйлдвэрлэл өсөх зэрэг болно.

Нөгөө талаас гадаадын ажилчид нь тэдгээрийг хүлээн авсан оронд дараах сөрөг талыг үүсгэдэг:

5. Үндэсний нийгмийн харилцаанд асуудал үүсгэх эх үүсвэр болдог,
6. Янз бүрийн нийгмийн зардал, нүүлгэн шилжүүлэхэд нөхөн төлбөр авдаг,
7. Шилжин ирэгсдийн нийгэмлэгийг байгуулснаар нийгмийн зөрчил, мөргөлдөөн хурцадна гэх мэт байна.

2008 оны 6-р сарын байдлаар гэхэд МУ-д 106 орны 38 0007 орчим гадаадын болон харьяалалгүй хүмүүс байна. Монгол Улс цагаач иргэдийг гаргадаг мөн хүлээн авдаг орон болсон харьяалалгүй хүмүүс байна. Монгол Улс цагаач иргэдийг гаргадаг мөн хүлээн авдаг орон болсон нь дээрхи тоо баримтаас харагдаж байна. Гэтэл монгол улсад цагаач иргэдтэй холбоотой эрх зүйн орчин байхгүй, цагаач ажилчид ба тэдний гэр бүлийнхний эрх ашгийг хамгаалсан олон улсын гэрээ конвенцид нэгдэн ороогүй байна.

Гадаадад шилжигсдийг илгээснээр улс орон нь дараах үр дүнг олж авна:

- ✓ Ажилгүйдэл буурна,
- ✓ Илүү хөгжилтэй оронд ажиллуулснаар өөрийнхөө боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлнэ,
- ✓ Мөнгөн гуйвуулгаар орлого орно,
- ✓ Хүн амын аж байдал өснө,
- ✓ Нийлмэл эрэлт нэмэгдэнэ.

Мөн шилжигсдийг илгээх нь сөрөг үр дагавартай байдаг:

- ✓ Хүн ам зүйн хүчин чадлыг бууруулна,
- ✓ Мэргэшсэн мэргэжилтнээ гадагшаа алдана,
- ✓ Мөнгөн гуйвуулгаас төлбөрийн балансын хамааралд сөрөг үр нөлөө үзүүлнэ,
- ✓ Нийгмийн, соёлын, гэр бүлийн холбоог алдагдуулна.

Иймд шилжилтийн эдийн засгийн үр дагавар нь шилжигсдийг хүлээн авч байгаа болон илгээж байгаа оронд нэгэн адил байдаггүй.

Дэлхийн санхүүгийн хямрал 2008 оны сүүлээс эхлэн Монголын эдийн засагт дотоодын эрэлт буурах, гадаад худалдааны хэмжээ багасах, төсвийн орлого хумигдах, банкны зээл зогсох, уул уурхай, барилга, гадаад худалдаа, үл хөдлөх хөрөнгийн салбар уналтанд орох зэрэг гол шинж тэмдгүүдээр илэрч байна. Харин хөдөлмөрийн зах зээлд хямрал бүртгэлтэй ажилгүйчүүд ихсэх, албан ёсны секторт шинээр ажилд авалт зогсонги байдалд орох, бусад улс орны эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан гадаадад ажиллах хүчний шилжих хөдөлгөөн буурах, эсрэгээр гадаадад ажиллаж байсан хүмүүс буцаж ирэх, гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулгын хэмжээ багасах зэрэг байдлаар илэрч байна.

Бүхэлдээ хүн амын тэнцвэргүй шилжилтийн үед ажиллах хүчний олон улсын шилжилт нь улс орны үндэсний эдийн засгийн ажил эрхлэлтийн салбар болон эдийн засгийн хөгжилд сөрөг чиг хандлагыг бий болгодог. Үүнд: шилжилтийн арилжаанд идэвхтэй оролцох, нэг бүс нутгийн эдийн засгийн доройтол, хүн амгүй болох, нөгөө бүс нутгийн хүн амын хэт нягтралыг бий болгодог. Мөн хүн амын түргэн шилжилт болон түүний нутаг дэвсгэрийн дахин хуваарилалтын тодорхой түвшинг хангаснаар олон улсын шилжилт нь хүн амын хөдөлмөрийн үндэсний зах зээлийн бүтэц, эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл болох хөдөлмөрийн чадвартай хүн амын ажил эрхлэлтийн бүрдлийн өөрчлөгдөх боломжийг бий болгодог. Хөдөлмөрийн глобалчлагдсан зах зээл болон дэлхийн эдийн засгийн хувьд шилжилт нь хөдөлмөрийн нөөцийн бүтцийн оновчтой байдлыг нөхцөлдүүлдэг эерэг үзэгдэл гэж харагдаж байна.

Шилжилтийн механизм нь шилжих хөдөлгөөний урсгалуудыг дамжин биелэгддэг. Бүх газар нутаг нь янз бүрийн эрчим, чанарын бүтэц, чиглэлээр хийгдэх шилжилтийн урсгалаар хоорондоо холбоотой байдаг. Дэлхийн шилжих хөдөлгөөний сүлжээний мөн чанарын тухай яриа нь олон улсын шилжих хөдөлгөөний хамрах хүрээг нотолдог.

Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизм нь дараах үүргийг биелүүлэх ёстой:

- Ажиллах хүчнийг ашиглах хэлбэр, аргыг хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлттэй зохицуулах,
- Амьдран суух газар, мэргэжил, хөдөлмөрийн үйл ажиллагааны хэлбэрээ сонгох, эрх чөлөөтэй явах гэх мэт хүний эрхийг биелүүлэх,
- Ажиллах хүчийг эзэмшигч болох иргэн, ажил олгогч, улсын бүгдийнх нь сонирхолын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх,
- Улс орны хөдөлмөрийн нөөцийн тоон болон чанарын шинж чанарыг тодорхойлох,
- Бүрэн ажил эрхлэлтийг хангахад тус болох гэх мэт байна.

Иймд ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизм нь дэлхийн аж ахуйн бүс нутгийн хөдөлмөрийн нөөцийн тоон болон чанарын параметруудийг тогтоох улс хоорондын мэдээллийн болон хөдөлмөрийн солилцоог хангадаг. Мөн дэлхийн эдийн засгийн хямрал нь олон улсын шилжих хөдөлгөөний

хүндэрч байгаа механизмыг өөрчлөх, эдийн засгийн идэвхитэй хүн амын шилжилтийн солилцоонд оролцдог ажиллах хүчийг эзэмшигч иргэн, ажил олгогч, улсын сонирхолын тэнцвэрийг алдагдуулахад хүргэдэг.

Ажиллах хүчний олон улсын шилжилтийн механизмын хөдлөлийн үр дүн нь тогтоосон шинжүүрт зохицохгүй сөрөг гэж үнэлэгдэж болох нь ойлгомжтой ч улс орнуудын явуулдаг шилжилтийн бодлогын зарчмыг чангатгахад хүргэдэг.

Монгол улс нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөний асуудлыг зохицуулж байгаа хэдий ч шилжин суурьшигсад ээлтэй бодлогын шинжтэй баримт бичиг байхгүй байна. Шилжилт хөдөлгөөний зохисгүй байдлаас болж иргэд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол улсын Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүй байна. Ялангуяа зохистой орон байраар хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч

боловсрох, сонгуульд оролцох эрх нь зөрчигдсөөр байна. Гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбогдон гарч буй монголчуудын эрх ашгийг хамгаалах, иргэдээ бүртгэх, нэгдсэн мэдээллийн баазыг бий болгох, уг харилцаатай холбоотой дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монголчууд олноор ажиллаж, сурч буй орнуудын элчин сайдын яамны дэргэд хүний эрхийн асуудал хариуцсан атташе ажиллуулах, мөн гадаадад ажиллаж буй иргэд буюу гадаадаас монгол улсад ирж ажилаж буй цагаач ажилчдын эрх ашгийг хамгаалах үүднээс “Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах” тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орох шаардлагатай. Өнөөг хүртэл МУ-ын Засгийн газар Дүрвэгсдийн асуудлаар нэгдсэн мэдээлэл, тоо баримт байхгүй, дүрвэн ирсэн болон гарсан иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй учир энэ талаар мэдээ баримтыг цэгцлэх, олон нийт, хүний эрхийн байгуулагуудад нээлттэй болгох шаардлагатай.

Ном зүй:

1. Б.Баярдаваа, Д.Гансүлд. Макро экономикс. Улаанбаатар. 2006.
2. Одегов Ю.Г.,Руденко Г.Г.,Экономика труда. М.,2007
3. Рыбаковский Л.Л., Механизмы формирования миграционных потоков //Миграция и развитие.М.,2007
4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2010 оны 2 дугаар сард хийсэн ажлын тайлан
5. Ионцев.В., Международная миграция, глобализация и развитие//Миграция и развитие . М., 2007
6. Народонаселение: Энциклопедический словарь.М.,1994